

“ТӨРИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ-2030”***Нэг. Нийтлэг үндэслэл***

1.1. “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030” (цаашид “Хөгжлийн стратеги” гэх) нь Монгол Улсын батлан хамгаалах бодлогын хүрээнд төрийн цэргийн байгууллагуудыг 2030 он хүртэл хөгжүүлэх зорилго, зорилт, арга замыг тодорхойлсон стратегийн баримт бичиг мөн.

1.2. Хөгжлийн стратегийн зорилго, зорилтыг Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Онцгой байдлын байгууллага үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Хоёр. Тулгарч буй сорилт, тулгамдсан асуудал***2.1. Тулгарч буй сорилт:***

- Дэлхий болон бүс нутгийг хамарсан шинж чанартай цэргийн болон бусад аюул, занал;
- Дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдал;
- Улс гүрнүүдийн геостратегийн ашиг сонирхолын зөрчил, сөргөлдөөн, газар нутаг, хилийн маргаан, шашин, үндэстэн хоорондын мөргөлдөөн, олон улсын терроризм, салан тусгаарлах хөдөлгөөн;
- Зэвсэгт тэмцлийн хэрэгслийн үсрэнгүй хөгжил, цэрэг-аж үйлдвэрийн өрсөлдөөн, цэргийн урлагт гарч буй өөрчлөлт;
- Үндэстэн болон хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн тархалт;
- Уур амьсгалын өөрчлөлт, хүн, малын гоц халдварт шинэ төрлийн өвчин, хими, радиац, биологийн хорт бодисоос хамааралтай аюул;
- Монгол Улсын эдийн засгийн боломж, нөөцийн хязгаарлагдмал байдал;
- Монгол Улсад цэргийн аж үйлдвэрлэлийн үндэс тавигдаагүй байдал.

2.2. Тулгамдсан асуудал:

- Төрийн цэргийн байгууллагуудын эрх зүйн цогц байдал бүрэн бүрдээгүй;
- Төрийн цэргийн байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх боломж, нөөц хязгаарлагдмал;
- Зэвсэглэл, цэргийн болон тусгай техник, тоног төхөөрөмж технологийн хувьд үндсэндээ хоцрогдсон;
- Улсын хилийн нөхцөл байдал, техник технологийн дэвшилтэд нийцүүлэн хил хамгаалалтын арга, хэрэгслийг сайжруулах шаардлага үүссэн;
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулах шаардлага үүссэн;
- Цэргийн алба хаагчдын алба хаах, амьдрах орчин, нөхцөл бүрэн бүрдээгүй.

Гурав. Хөгжлийн стратегийн зорилго

3.1. Цэргийн мэргэжлийн өндөр бэлтгэлжилттэй бие бүрэлдэхүүн, шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан орчин үеийн зэвсэглэл, цэргийн техник бүхий чадварлаг Зэвсэгт хүчнийг байгуулах;

- 3.2. Улсын хил хамгаалалтыг шинжлэх ухаан, техник, технологийн ололт, мэргэшсэн байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулах;
- 3.3. Гамшгаас хамгаалах эрсдэлийн цогц удирдлагыг хэрэгжүүлж, мэдлэг, ур чадвар, мэргэшил бүхий алба хаагчийг хөгжүүлэх замаар онцгой байдлын байгууллагын чадавхийг бэхжүүлэх.

Дөрөв. Хөгжлийн стратегийн зорилт

4.1. Зэвсэгт хүчин:

- 4.1.1. Эрх зүйн орчин, стратегийн төлөвлөлт, бүтэц, зохион байгуулалт, бие бүрэлдэхүүний нөхөн хангалт, цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилт, чадавхийг нэмэгдүүлнэ.
- 4.1.2. Дэвшилтэт технологид суурилсан холбоо, мэдээллийн хэрэгслийг нэвтрүүлж, кибер халдлагатай тэмцэх чадавхи бүхий төрийн цэргийн удирдлагын нэгдмэл тогтолцоог бүрдүүлнэ.
- 4.1.3. Мэргэшсэн чадварлаг бүрэлдэхүүнтэй, хөдөлгөөн, гал, цохилтын өндөр боломжтой Хуурай замын цэргийг байгуулж, бэхжүүлнэ.
- 4.1.4. Агаарын хил, орон зайг бүрэн хянах, нийслэл хот, стратегийн чухал объектыг хамгаалах чадавхи бүхий Агаарын цэргийг байгуулж, бэхжүүлнэ.
- 4.1.5. Зэвсэглэл, цэргийн техник хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.1.6. Зэвсэгт хүчний материал, техникийн хангалт, үйлчилгээний тогтолцоог оновчтой болгож, цэргийн анги, салбарыг хүний хөгжлийн орчин болгоно.

4.2. Хилийн цэрэг:

- 4.2.1. Улсын хил хамгаалалтын эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд хил хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгоно.
- 4.2.2. Хилийн боомт, усан хил хамгаалалт /Буйр нуур/-ыг зохион байгуулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.2.3. Хилийн албаны сургалт бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, цэргийн гэрээт албыг бэхжүүлнэ.
- 4.2.4. Хил хамгаалах орчин үеийн техник, технологийг нэвтрүүлнэ.
- 4.2.5. Улсын хил хамгаалалтад орон нутгийн удирдлага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хил орчмын нутаг дэвсгэрт иргэд тогтвортой суурьших нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.2.6. Хил хамгаалалтын дэд бүтцийг хөгжүүлж, хилчдийн алба хаах, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

4.3. Онцгой байдлын байгууллага:

- 4.3.1. Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, гамшгийн эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгоно.
- 4.3.2. Цэргийн албанд тулгуурласан онцгой байдлын байгууллагыг төлөвшүүлнэ.
- 4.3.3. Гамшгаас хамгаалах эрсдэлийн удирдлагын манлайлал, мэдлэг, оролцоог сайжруулж, мэргэжлийн ур чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлнэ.
- 4.3.4. Гамшгийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, шинэ мэдлэг, дэвшилтэт техник, технологи, инновацийг нэвтрүүлж, гамшиг судлалыг хөгжүүлнэ.
- 4.3.5. Онцгой байдлын байгууллагын анги, салбарын чадавхийг бэхжүүлнэ.
- 4.3.6. Байгалийн болон хүний хүчин зүйлээс хамааралтай гамшиг, ослын үеийн төрийн цэргийн бусад байгууллагын оролцоог нэмэгдүүлнэ.

Тав. Хөгжлийн стратегийг хангах арга зам

- 5.1. Монгол Улсын Засгийн газар бүрэн эрхийн хугацаандаа Хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг батална.
- 5.2. Санхүүгийн эх үүсвэр нь улсын төсөв, хөтөлбөр, төсөл, гадаадын зээл, хандив, тусламж, байгууллагын дотоод нөөц байна.
- 5.3. Хөрш хоёр гүрэн, бусад улс орон, олон улсын байгууллагатай хөгжүүлэх хамтын ажиллагаанд тулгуурлана.
- 5.4. Шинжлэх ухааны хөгжил, дэвшилтэт техник, технологи, инновацийг ашиглана.
- 5.5. Мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийн боломжид суурилна.
- 5.6. Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо, хэвлэл мэдээллийн байгууллагын дэмжлэгт тулгуурлана.

Зургаа. Хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн

- 6.1. Хөгжлийн стратегийг 2030 он хүртэл дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат: 2016-2020 он;
 Хоёрдугаар үе шат: 2020-2024 он;
 Гуравдугаар үе шат: 2024-2030 он.

- 6.2. Хүрэх үр дүн

Нэгдүгээр үе шат (2016-2020):

- Төрийн цэргийн байгууллагын эрх зүйн орчин боловсронгуй болж, хамтын ажиллагаа төлөвшинэ.

- Зэвсэглэл, цэргийн болон тусгай техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн эхлэл тавигдана.
- Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийн төвшин дээшилнэ.
- Улсын хил хамгаалалтын тогтолцоо боловсронгуй болно.
- Гамшгийн эрсдэлийн удирдлага боловсронгуй болж, цэргийн албанд тулгуурласан онцгой байдлын байгууллага төлөвшинэ.

Хоёрдугаар үе шат (2020-2024):

- Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхи нэмэгдэнэ.
- Зэвсэглэл, цэргийн техникийн шинэчлэл 40-өөс доошгүй хувь, онцгой байдлын байгууллагын тусгай зориулалтын багаж хэрэгсэл, техник хэрэгслийн хангамж 60 хувьд хүрнэ.
- Улсын хил хамгаалалт бүсчилсэн тогтолцоонд шилжсэн байна.
- Гамшгийн эрсдэлийн удирдлага жигдэрч, олон улсад эрэн хайх, аврах ажиллагаа явуулах үндэсний баг, бүсийн төвийн онцлогт тулгуурласан хүмүүнлэгийн тусламжийн ложистикийн төв байгуулагдаж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо нэмэгдэнэ.

Гуравдугаар үе шат (2024-2030):

- Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчин бүрдэнэ.
- Мэргэшсэн бүрэлдэхүүнд тулгуурласан, орчин үеийн техник, технологи, дэд бүтэц бүхий улсын хил хамгаалалтын нэгдсэн тогтолцоо бүрдэнэ.
- Онцгой байдлын анги, салбарын чадавхи олон улсын жишигт ойртсон байна.
- Хөгжлийн стратегийг бүрэн хэрэгжүүлсэнээр цаашдын хөгжлийн урт хугацааны бодлого боловсруулах нөхцөл бүрдэнэ.